

Улсын нэгдсэн бүртгэлийн 2015...оны 10..р  
сааралын 27-ны одрийн 3569 дугларт бүртгэв.  
Монгол Улсын Хууль зүйн яам



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2015 оны 10 сарын 12-адар

Дугаар 4/5

Улаанбаатар хот

Галт зэвсгийн гэрчилгээний загвар,  
гэрчилгээ олгох журам батлах тухай

Галт зэвсгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийг үндэслэн  
ТУШААХ нь:

1."Галт зэвсгийн гэрчилгээний загвар"-ыг нэгдүгээр, "Галт зэвсгийн гэрчилгээ  
олгох журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тушаалыг үйл ажиллагаандaa мөрдөж ажиллахыг төв, орон нутгийн цагдаагийн  
байгууллагын дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга /дэд  
комиссар Ж.Буянбат/-д үүрэг болгосугай.

3.Тушаалыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА,  
ТЭРГҮҮН КОМИССАР

Р ЧИНГИС

ХУУЛБАР ҮНЭН  
Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтсийн дарга,  
цагдаагийн хурандаа

Б Батсуурь



0902692

## ГАЛТ ЗЭВСГИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

Нэг. БҮРТГЭЛИЙН СЕРИ:

онд.....уулдвэрлэсэн.....маркийн  
улсад.....онд.....

1. гол төмрийн № ..... замагны № .....  
гол төмрийн голчийн хэмжээ, сум.....  
2. галт зэвсгийн сумны төрөл, зориулалт  
голт зэвсгэг өмчлөхийг зөвшөөрч улсын нэгдсэн бүртгэд бүртгэв.

Улсын хилээр орж ирсэн огноо .....

ХЭЛТСИЙН ДАРГА АЙМАГ, ХОТЫН ЦАГДААГИЙН ГАЗАР,  
Эрхэлсэн ажил, хуулийн этээдийн үйл ажиллагааны чиглэл

он . . . сар . . . ёдөр

ЦЕГ 000000

Цагдаагийн ерөнхий газрын дарлын  
2015 оны 10 дугаар сарын 1-ны  
өдрийн 11 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

### Хоёр. ГАЛТ ЗЭВСГЭГ ӨМЧЛӨГЧ

Эзраг

Өмчлөгчийн ургийн овог,  
эцэг/эх-ийн нэр, өөрийн нэр  
(Байгууллагын нэр)

Регистрийн дугаар .....

Улсын бүртгэлийн дугаар .....

Өмчлөх зориулалт .....

Сургалтад хамрагдсан байдал, гэрчилгээний дугаар .....

Хаяг .....

Эрхэлсэн ажил, хуулийн этээдийн үйл ажиллагааны чиглэл .....

АЙМАГ, ХОТЫН ЦАГДААГИЙН ГАЗАР,  
ХЭЛТСИЙН ДАРГА .....

он . . . сар . . . ёдөр

Тусгай тэмдэглэл .....

ГУРАВ. ХАМТРАН ЭЗЭМШИГЧ

34par

Регистрийн дугаар .....  
Улсын бүртгэлийн дугаар .....  
Эзэмших зорилт .....  
Сургалтад хамрагдсан байдал, гэрчилгээний дугаар

Эрхэлсэн ажил АЙМАГ, ХОТЫН ЦАГДААГИЙН ГАЗАР ХЭЛССИЙН ДАРГА

Он... сар... едер

ЛЕПЕДЕЖНІЙ БЫТ ТІСІ

|    |           |           |  |
|----|-----------|-----------|--|
|    |           |           |  |
| ОН | сар, өдөр | Тэмдэглэл | Цагдаагийн<br>ажилтны<br>гарын үсэг,<br>тэмдэг |

**Тав. ТАТВАРЫН ТЭМДЭГЛЭЛ**

**ЗУРГАА. ЭЗЭМШИГЧИЙН ҮҮРЭГ**

|    |           |           |                                       |
|----|-----------|-----------|---------------------------------------|
| Он | сар, өдөр | Тэмдэглэл | Цагдаагийн ажилтын гарын үсэг, тэмдэг |
|    |           |           |                                       |
|    |           |           |                                       |
|    |           |           |                                       |
|    |           |           |                                       |
|    |           |           |                                       |
|    |           |           |                                       |
|    |           |           |                                       |

1. Монгол Улсын иргэн, хуулийн этгээд өөрийн ёмчлөл, эзэмшилд байгаа галт зэвсэгтэй адилттах хэрэгслийг буртуулсан зориулалттар нь аюулгүй ажиллагаатай хянан ашиглах эрхтэй.
2. Галт зэвсэгт ёмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэн галт зэвсийн тох, эсхүл замийг цоожилж, сумыг тусад нь түүжээтэй шүүгээ /савы-/нд, хадгалах ба галт зэвсгээс замийг салтлах боломжтой бол замийг салгаж хадгална.
3. Галт зэвсийг хэрж, алдаж урэгдуулсан тохиолдолд энэ талаар мэдсэн даруудаа цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.
4. Галт зэвсгийг авч явахдаа гол, эсхүл замийг цоожилж, сумыг тусад нь байлгаж, зориулалтын сав /хайрцаг/-нд, хийн аюулгүй байдлыг ханган, галт зэвсгийн герчилгээний хамт авч явна.
5. Галт зэвсгээ жил бүр оршин суугаа газрын цагдаагийн байгууллагад буртуулж тооллогод оруулан татвараа төвлө.
6. Галт зэвсгийг буртуулснаас өөр зориулалттар болон хот, суурин газарт ашиглахыг хориглоно.
7. Галт зэвсэгт дуу намсахаа хэрэгсэл, байланы зориулалттай шөнийн харааны хэрэгсэл сууринуулахыг хориглоно.
8. Галт зэвсийн хэлбэр, хийцийг өөрчлөхийг хориглоно.

Тайлбар

Тусай тэмдэглэл буюу ёмчлөгч, хамтран эзэмшигч нь галт зэвсэгт ашиглаж гэмт хэрэг санаатай үйлдэж байсан эсээний шалгасан байдал

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Цагдаагийн өрөнхий газрын даргын  
2015 оны 10 дугаар сарын 12-ны  
өдрийн 11 дугаар тушаалын  
хөөрдугаар хавсралт

## ГАЛТ ЗЭВСГИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Цагдаагийн байгууллагаас галт зэвсгийн гэрчилгээ олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулиар зөвшөөрөгдсөн этгээд галт зэвсэг ёмчлех, зэмзүүлэх, ашиглах хүснэгт гаргасан иргэн, хуулийн этгээдэд гэрчилгээ олгоход хууль дээдлэх, иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, төрийн байгууллагын үйл ажиллагаа шуурхай байх зарчмыг баримтална.

1.3. Цагдаагийн байгууллагаас "Галт зэвсгийн гэрчилгээ" авснаар иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг зэмзүүлэх, ашиглах, ёмчлех эрх үүснэ.

### Хоёр. Галт зэвсгийн гэрчилгээ олгоход тавигдах шаардлага

2.1. Цагдаагийн байгууллага, алба хаагч галт зэвсэг ёмчлех хүснэгт гаргасан иргэн, хуулийн этгээдэд гэрчилгээ олгоход Галт зэвсгийн тухай хуулийн 9, 10, 12 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан үзнэ.

### Гурав. Галт зэвсгийн гэрчилгээ олгох

3.1. Аймаг, хотын цагдаагийн байгууллага нь иргэн, хуулийн этгээдээс бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авч ажлын 10 хоногийн дотор судалж, шалгаад, галт зэвсгийн гэрчилгээ олгох эсэх асуудлыг шийдвэрлэнз.

3.2. Галт зэвсгээ бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдэд галт зэвсгийн гэрчилгээ олгоход Галт зэвсгийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан бүрдлийг болон галт зэвсэг ашиглаж санаатай гэмт хэрэг үйлдэж байсан эсэхийг шалгасан байдал, галт зэвсэг зэмзүүлэх, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан талаарх тэмдэглэгээг тус тус тусгана.

3.3. Иргэн, хуулийн этгээдэд галт зэвсгийн гэрчилгээг аймаг, нийслэлийн цагдаагийн газар, хэлтсийн дарга олгоно.

3.4. Галт зэвсгийн гэрчилгээний бүртгэлийн сери нь 2 үсгээр тэмдэглэгдэнэ. Серийн эхний тэмдэглэгээ нь тухайн галт зэвсгийн бүртгэсэн аймаг, дүүргийг, дараагийн тэмдэглэгээ нь тухайн иргэн, хуулийн этгээдийн оршин байгаа сум, хороог илэрхийлнэ.

3.5. Галт зэвсгийн гэрчилгээний дугаар нь 6 оронтой тооноос бурдэнэ. Энэ сери, дугаар нь хамтдаа галт зэвсгийн улсын бүртгэлийн дугаар болох бөгөөд дугаар авагдсан галт зэвсгийг мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

3.6. Улсын бүртгэлтийн дугаар олгосон галт зэвсэгт галт зэвсгийн бүртгэлийн карт 2 хувь үйлдэж, нэг хувийг сумны хонгио, хошуу, дагалдах хуудасны хамт аймаг, нийслэлийн хэв журмын албанд хүргүүлнэ.

3.7. Лицензийн төв нь аймаг, хотын цагдаагийн газар, хэлтсээс ирүүлсэн материалыг хүлээн авч бүртгэлийн картыг галт зэвсгийн нэгдсэн бүртгэлийн санд бүртгэж, орон нутгийн шүүхийн шинжилгээний албанаас хонгио, хошуу, дагалдах хуудсыг авч, шүүхийн шинжилгээний хурээлэнд хүргүүлнэ.

Галт зэвсэг худалдаж авсан, улсын хилээр оруулсан иргэн, хуулийн этгээд нь галт зэвсгийн сумны хонгио, хошууны дээжийг шүүхийн шинжилгээний байгууллагын мэдээллийн санд бүртгүүлсэн эсэхэд цагдаагийн байгууллага хяналт тавина.

3.8. Эрүүгийн цагдаагийн газар, хэлтэс, тасаг нь эрэн сурвалжлагдаж байгаа галт зэвсгийн тухай мэдээллийг аймаг, хотын цагдаагийн газар, хэлтсийн галт зэвсэг хариуцсан хэв журмын алба хаагчид тухай бүр хүргүүлж байна.

3.9. Цагдаагийн төв байгууллагын Санхүү, хангамжийн газар нь галт зэвсгийн гэрчилгээг нэгдсэн журмаар хийлгэж, аймаг, хотын цагдаагийн газар, хэлтсийн захиалгаар хуваарилан олгоно.

#### **Дөрөв. Галт зэвсгийн гэрчилгээнд хамтран зээмшигч, зээмшигчийг бүртгэх**

4.1. Цагдаагийн байгууллага, алба хаагч нь галт зэвсгийн хамтран зээмшигч, зээмшигчийг бүртгэхдээ Галт зэвсгийн тухай хуулийн 9.1, 10.1, 10.2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан тохиолдолд хамтран зээмшигч, зээмшигчээр тус тус бүртгэнэ.

4.2. Галт зэвсэг тавьж олгосон хуулийн этгээд нь тухайн галт зэвсгийн ашиглалтад хяналт тавьж, аюулгүй байдлыг хангах зааварчилгааг тухай бүр өгч ажиллас уүрэгтэй болохыг цагдаагийн байгууллагаас бүртгэлийн гэрчилгээ олгоходо тайлбарлаж өгнө.

#### **Тав. Галт зэвсгийг бүртгэлээс хасах, шилжүүлэг хийх**

5.1. Галт зэвсгийг өмчлөх иргэн, хуулийн этгээд нь оршин байгаа газраасаа вэр аймаг, дүүрэгт шилжих зорилгоор галт зэвсгээ нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын бүртгэлээс хасуулсан тохиолдолд шилжин очиж буй нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад нь хасалт хийсэн алба хаагч мэдэгдэнэ.

Галт зэвсгийг бүртгэлээс хассан, шинээр бүртгэсэн тухай тэмдэглэлийг галт зэвсгийн гэрчилгээнд тэмдэглэл үйлдэнэ.

5.2. Иргэн, хуулийн этгээд өмчлөлдөө байгаа галт зэвсгийг бусдын өмчлөлд шилжүүлэх бол нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад шилжүүлэн өгч байгаа болон шилжүүлэн авч байгаа этгээд хоёулаа бичгээр өргөдөл, хүсэлтийг үндэслэн галт зэвсгийн гэрчилгээнд тэмдэглэл хийлгэж, бүртгэлээс хасуулна.

Галт зэвсгийн бүртгэлийн картын тусгай тэмдэглэлд бүртгэлээс хассан тухай тэмдэглэл хийж, хеделгээний мэдээг тухай бүр галт зэвсгийн нэгдсэн бүртгэлийн санд бүртгэнэ.